

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

- Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/
Зарим хүмүүс сэтгэцийн эмнэлэгт хэвтэх, шоронд хоригдох, итгэж байсан зүйлээсээ ухарч, хатуу ширүүн дэг журамд дасан зохицох, өөрийгөө хүлээж авах дүр зургаа өөрчлөх гарцаагүй нөхцөлд ордог. Үүнийг гэдэг.
A. Нийгэмшилтийн агент B. Адилсал C. Нийгэмшилт
D. Дахин нийгэмшилт E. Нийгмийн гажуудал
- Бүтэц чиг үүргийн онолын гол төлөөлөгч Р.Мертон нийгмийн институтийн чиг үүргийн хэлбэрүүдийг тодорхойлсон байдаг. Ил чиг үүрэгт хамаарах өгөгдөл аль нь вэ? /1 оноо/
A. Тухайн үйлдэгч урьдчилан тооцоолоогүйгээр бий болсон үр дагавар
B. Тухайн үйлдлийг гүйцэтгэгчээс мэдэж тооцоолсон үр дагавар
C. Үйлдэл нь зорьсныхоо эсрэг үр дагаварт хүргэх
D. Тухайн байр суурь бүхий хүн юуг хийх нь зөвшөөрөгдөж байгаа үйлдэл
E. Тухайн байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой үйлдэл

- Дараах хүснэгтээс нийгмийн гажуудлын тодорхойлолт болон гажуудалд хамаарах жишээг олно уу. /2 оноо/

Хүснэгт-а		Хүснэгт-б	
1	Нийгэм болон нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хүлээлтэд үл нийцэх төлөв	1	Монгол улсад 2015 онд нийт 24857 гэмт хэрэг бүртгэгдсэн. Үүнээс ажилгүйчүүдийн үйлдсэн гэмт хэргийн тоо нь 12532 байв.
2	Нийгмийн хэм хэмжээ, хүлээлтэд нийцэх төлөв	2	Нийтийн зориулалттай орон сууцанд шөнийн цагаар бусад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан бол 100 мянган төгрөгөөр торгоно.
3	Гажуудал бол нийгмээсээ хамаараад харьцангуй мөн чанартай	3	Сурагч Э дүрэмт хувцсаа өмсөж ирээгүй тул ангийн дарга зэмлэв.

A. a-3, b-3 B. a-2, b-2 C. a-2, b-1 D. a-1, b-3 E. a-1, b-1

- Социологич Д.Датон ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгааг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч байна гэж үзсэн. Хүснэгт дэх өгөгдлийг ажиглаад орхигдсон хүчин зүйлийг гүйцээгээрэй. /1 оноо/

Д.Датон	Санхүүгийн боломж
	
	Нийгмийн институтийн саад бэрхшээл

A. Ядуусын соёл B. Хувийн хүчин зүйл C. Хувийн хичээл зүтгэл
D. Санхүүгийн эрх чөлөө E. Ур чадвараар бага, даржин амьдрал

- Нийгмийн тэгш бус байдал, давхраажилт оршин байгаагийн учир шалтгааныг тайлбарласан “социологийн сонгодог үе”-ийн төлөөлөгчдийг сонгоно уу. /1 оноо/
A. М.Вебер, О.Райт B. К.Маркс, О.Райт C. М.Вебер, Дункан
D. К.Маркс, М.Вебер E. О.Райт, Л.Уорнер
- Судлаач О.Мөнхбатын “дунд” ангийн талаарх дүгнэлтэд үл хамаарах өгөгдлийг олно уу. /1 оноо/
A. Томоохон компанийн болон үйлчилгээний байгууллагын салбарын менежер багтдаг.
B. Тусгай дунд боловсролтой, төрийн болон хувийн байгууллагад ажил эрхэлдэг хүмүүс багтдаг.
C. Цэрэг, цагдаагийн дээд, дунд тушаалын офицер, шүүх байгууллагын албан хаагчид багтдаг.
D. Банк санхүү, томоохон аж ахуйн нэгжийн захирал, соёл, спортын элит бүлэг багтдаг.
E. Төр засгийн дунд албан тушаалтан, хэрэгжүүлэгч агентлагийн удирдлагууд багтдаг.



7. Байр суурийн шилжих хөдөлгөөний хэлбэрүүдийг өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

а. Босоо чиглэлийн шилжих хөдөлгөөн	1	Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан төрөлхийн байр суурьтай нь тодорхой хувь хүний олдмол байр суурийг харьцуулахад өөрчлөгдсөн бол
	2	Эцэг эх, гэр бүлийн төрөлхийн байр суурьтай нь харьцуулалгүйгээр хувь хүний байр суурь өөрчлөгдсөн бол
б. Үе дотоодын шилжих хөдөлгөөн	3	Хувь хүний нийгэм, эдийн засгийн байр суурь өөрчлөгдвөл
с. Бүлгийн шилжих хөдөлгөөн	4	1990 онд МУ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжсэнээр төрийн татаасаар ажилладаг үйлдвэрүүд хаагдаж, олон нэхмэлчин, гуталчин, ээрмэлчин ажилгүйдлийн эгнээнд орсон.
	5	Тодорхой хувь хүнээс хамааран, түүний хичээл зүтгэл, авьяас чадвар, хөдөлмөрийн үр дүнд байр суурь нь өөрчлөгдөх

- A. a5, b1, c4 B. a2, b5, c3 C. a3, b2, c4 D. a3, b2, c1 E. a2, b3, c1

8. Дараах тоон мэдээллийг ашиглан эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэргийн хувийн жинг тооцно уу. /2 оноо/

Нийгмийн байдлаар	Тоо	Нийгмийн байдлаар	Тоо
1. Ажилгүй	12532	2. Сурагч	644
3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч	4501	4. ТББ-ын ажилтан	465
5. Хувийн хэвшилд ажиллагч	2212	6. Тэнэмэл	190
7. Малчин	2144	8. Хоригдол	45
9. Төрийн албан хаагч	1018	10. Сургууль завсардсан	38
11. Оюутан	1053	12. Хугацаат цэргийн албан хаагч	15
Нийт			24857
Эрэгтэй	21075	Эмэгтэй	3782

- A. 21075 B. 152,1 C. 3782 D. 0,15 E. 15,2

9. Доорх өгөгдлүүдийн “үнэн”, “худал”-ыг тогтооно уу. /2 оноо/

№	Өгөгдөл	Үнэн	Худал
1	Нийгмийн өөрчлөлт нь ан агнуурын нийгмээс цэцэрлэгжүүлэх улмаар хөдөө аж ахуйн, түүнээс орчин үеийн нийгэм рүү хувьсан өөрчлөгддөг хэмээн Г.Ленский, Ж.Ленский нар үзсэн.		
2	М.Веберийн хувьд хүрээлэн буй орчинд дасан зохицох бус, харин түүнийг өөрчилдөг гэдэгт анхаарлаа хандуулдаг.		
3	М.Вебер нийгэм өөрчлөгдөхөд эдийн засгийн адил төр, арми, шашин чухал үүрэг гүйцэтгэдэг.		
4	Марксистууд гэнэтийн өөрчлөлт нь тэгш бус байдлыг өөрчилж, шударга ёсыг тогтооход чухал үүрэгтэй гэж үздэг.		

- A. 1 үнэн, 2 худал, 3 үнэн, 4 үнэн B. 1 үнэн, 2 үнэн, 3 худал, 4 үнэн
C. 1 үнэн, 2 худал, 3 үнэн, 4 худал D. 1 худал, 2 худал, 3 үнэн, 4 үнэн
E. 1 худал, 2 үнэн, 3 үнэн, 4 үнэн

10. Германы социологич Э.Кассирерын үзэл санаанд хамаарах ойлголтыг сонгоно уу. /1 оноо/

- A. Хүн гэдэг бол бэлгэдлийн амьтан
B. Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан
C. Хүн гэдэг амьтны адгууснаас ялгарч буй гол шинж нь бэлгэдэл
D. Тэмдгийн илэрхийлж буй далд утгыг бэлгэдэл гэдэг
E. Бэлгэдэл бол дохио тэмдгийн дараагийн түвшин



11. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тохирох жишээтэй нь зөв тохируулна уу. /1 оноо/

a. Бэлгэ тэмдэг	1	Гараа эвхээд суух нь сэтгэл санаа тогтворгүй, зовнисон байгааг илтгэнэ.
	2	Хүмүүсийн харилцан үйлдэл харилцаа, түүний үр дагавар, түүнээс үүсэх зөрчилдөөнийг социологийн шинжлэх ухаан судалдаг.
b. Хэм хэмжээ	3	Монгол улсын ерөнхийлөгч нь ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.
c. Хэл	4	Малчид болжмор бөөгнөрөхөд цас ордог, галуу дуугарахад бороошдог хэмээн хэлэлцдэг.
	5	Монголчууд дээл, бүс, малгайг зөв сайхан өмссөн хүнийг уламжлал ёс жаягаа мэддэг хүн гэж үнэлдэг.

A. a1, b3, c4 B. a5, b1, c2 C. a3, b2, c4 D. a3, b5, c1 E. a5, b1, c3

12. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/

..... нь тухайн нийгмийн гишүүдийн дийлэнхэд нь зонхилж буй амьдрах зан үйл, үйлдлийн загварыг тодорхойлогч соёл юм.

A. Дэд соёл B. Зонхилогч соёл C. Сөрөг соёл
D. Олон улсын соёл E. Улс үндэсний соёл

13. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлийг зөв тохируулна уу. /1 оноо/

Өгөгдөл: (1-Угсаатан, 2-Ястан, 3-Үндэстэн)

a	b	c
Нэг ижил нутгаас гаралгүй ч удирдагчдын нөлөөгөөр бүрэлдсэн нийтлэг бол юм.	Үндэс угсаа, хэл, аж ахуй, улс төрийн хувьд нийтлэг байхыг илэрхийлдэг ойлголт бол юм.	Үндэс угсаа, хэл, соёл, түүх, зан заншил, газар нутаг, шашин зэргээр нийтлэг нийгмийн бүлэг бол юм

A. a-1, b-3, c-2 B. a-2, b-1, c-3 C. a-2, b-3, c-1 D. a-3, b-2, c-1 E. a-1, b-2, c-3

14. Харь соёлд дасан зохицох 7 үе шат байдаг. Дараах үе шатуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

a. В шат b. D шат c. F шат	1	Шинэ соёлд дассан боловч, эргэн тойрныхоо хүмүүстэй харилцаа тогтоож чадахгүй.
	2	Харь хэл, орчин, хоол хүнс зэрэг шинэ зүйлсийг хүлээн авч чадахгүйгээс бухимдал үүснэ.
	3	Найз, нөхөдгүй, нийгмээс тусгаарлагдсан мэдрэмж төрнө.
	4	Шинэ орчинд бүрэн дасна.

A. a1, b3, c2 B. a2, b4, c3 C. a4, b1, c2 D. a2, b1, c3 E. a1, b4, c2

15. Доорх өгөгдлүүдийг соёлын түүхэн хэв маяг болон аж ахуй эрхлэлтийн шалгуурт нийцүүлэн ангилна уу. /2 оноо/

1. Нүүдэлчдийн соёл	2. Орчин үеийн соёл	3. Өрнийн соёл
4. Дорнын соёл	5. Сэргэн мандалтын соёл	6. Газар тариаланчдын соёл
a. Түүхэн хэв маяг		b. Аж ахуй эрхлэлт

A. a-2, 5 b-3, 4; B. a-1, 6 b-2, 5; C. a-3, 4 b- 1, 5;
D. a-1, 6 b-3, 4; E. a-2, 5 b-1, 6;

16. “Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хургасан нэгэн болгодог” гэж үзсэн нь хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/

A. Э.Фромм B. Дж.Кэмпбелл C. Ж.Локк D. К.Оберг E. Э.Тайлор



17. Тухайн нэрлэгдэж буй юмсын зарим гол шинж байдлыг түүнтэй холбоотой бусад шинж байдлуудаас нь салган сэтгэхүйдээ дүрслэх логик үйлдэл, аргыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Ойлголт В. Хийсвэрлэл С. Ерөнхийлөл D. Харьцуулалт Е. Анализ

18. Ямар нэгэн юманд тодорхой шинж харилцаа байгаа эсэхийг батлах юм уу үгүйсгэх байдлаар илэрхийлдэг сэтгэхүйн хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Анализ В. Харилцаат бодомж С. Ойлголт D. Бодомж Е. Харьцуулалт

19. Дараах ойлголтуудаас хийсвэр ойлголтыг олно уу. /1 оноо/

1. Аз жаргал	2. Санта Клаус	3. Дэвтэр
4. Төмөр зам	5. Бодол	6. Чөтгөр

- А. 3, 4 В. 1, 5 С. 2, 6 D. 1, 6 Е. 2, 5

20. Хүснэгтэд буй өгүүлбэрүүдээс бодомж болж чадах өгөгдлийг сонгоно уу. /1 оноо/

1. Та хаана амьдардаг вэ?
2. Угсаатан нь ястнаас том нийгмийн нийтлэг.
3. Монгол улс нь ерөнхийлөгчийн засаглалтай.
4. Улаанбаатар хот эндээс хол зайтай оршдог.

- А. 2, 4 В. 1, 3 С. 2, 3 D. 1, 4 Е. 3, 4

21. “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо”-ны үндсэн асуудал аль нь вэ? /1 оноо/

- А. Юуг-Яаж-Хэнд В. Яаж-Хэнд-Юуг С. Хэнд-Юуг-Яаж
 D. Юуг-Хэнд-Яаж Е. Яаж-Юуг-Хэнд

22. Зах зээл дээр барааны үнэ буурахад илрэх үзэгдэл аль нь вэ? /2 оноо/

- А. Зах зээлийн тэнцвэр бий болж тэнцвэрт үнэ тогтоно.
 В. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ өснө, нийлүүлэлтийн тоо хэмжээ өснө, илүүдэл үүснэ.
 С. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ буурна, нийлүүлэлтийн тоо хэмжээ буурна, хомсдол үүснэ.
 D. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ буурна, нийлүүлэлтийн тоо хэмжээ өснө, илүүдэл үүснэ.
 Е. Зах зээлд эрэлтийн тоо хэмжээ өснө, нийлүүлэлтийн тоо хэмжээ буурна, хомсдол үүснэ.

23. Дараах тоон мэдээлэл болон томъёог ашиглан МУ-ын 2024 оны эдийн засгийн өсөлтийг тооцно уу. /2 оноо/

№	Он	ДНБ (тэрбум)
1	2022	25
2	2023	30
3	2024	35
4	2025	40

Томъёо:

$$\text{ЭЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан} - \text{ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$

- А. 16% В. -16% С. -5% D. 5% Е. 0.16%

24. Эдийн засгийн онолын Физиократизмын үзэл баримтлал аль нь вэ? /1 оноо/

- А. Улс орны баялаг гүйлгээний хүрээнд бий болдог.
 В. Улс орны баялаг зөвхөн хөдөө аж ахуй, газар тариаланд л бүтээгддэг.
 С. Ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг.
 D. Цэвэр буюу төгс өрсөлдөөн нь тогтвортой байдлын өндөр зэргийг хангана.
 Е. Хүн болгоны ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа нь нийгмийн баялгийг бүтээдэг.

25. Үнэт цаас худалдан авагчдыг ердийн хүмүүс, өрсөлдөгчид, наймаачид гэсэн 3 хүрээнд хуваадаг. Тэгвэл өрсөлдөгчид хувьцааг ямар зорилгоор худалдан авдаг вэ? /1 оноо/

- А. Ямар нэгэн компанийн хувьцааг худалдан авах
 В. Өөрсдийн хуримтлалыг ногдол ашгаар арвижуулах
 С. Хувьцааг худалдах худалдан замаар ашиг олох
 D. Тухайн компанийг өөрийн эрхшээлдээ оруулах
 Е. Бүх төрлийн хувьцаа болон бонд, түүнийг худалдах, худалдан авах




26. Гүйлгээнд байх мөнгөний хэмжээг өсгөх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ? /1 оноо/
- A. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч, нийт эрэлт буурна.
 B. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар өсөж, нийт эрэлт нэмэгдэнэ.
 C. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар өсөж, нийт эрэлт буурна.
 D. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч, нийт эрэлт нэмэгдэнэ.
 E. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар тэнцвэржиж, эдийн засаг тогтворжино.

27. Эдийн засгийн дараах ойлголтуудыг агуулгатай нь зөв тохируулна уу. /2 оноо/

a. Валютын интервенц	1	Валютын ханш нь чөлөөтэй өсөж, буурах үзэгдэл
b. Валютын ревальваци	2	Төв банк өөрийн валютын нөөцөөс зардал гарган валютыг худалдан авна.
c. Валютын тогтмол ханш	3	Төв банкнаас валютын арилжааны ханшийг өсгөх
	4	Чөлөөтэй өсөж буурдаггүй валютын ханш

- A. a2, b3, c4 B. a3, b2, c1 C. a2, b1, c4 D. a3, b2, c4 E. a1, b2, c3

28. График дахь мэдээллийг ашиглан өгөгдөлд тохирох зөв дүгнэлтийг сонгоно уу. /2 оноо/



- A. 2020 онд гипер, 2023 онд мөлхөө, 2026 онд цогцо инфляци, 2020-2026 онд инфляци буурсан.
 B. 2020 онд цогцо, 2023 онд гипер, 2026 онд мөлхөө инфляци, 2020-2026 онд инфляци буурсан.
 C. 2020 онд цогцо, 2023 онд мөлхөө, 2026 онд гипер инфляци, 2020-2026 онд инфляци өссөн.
 D. 2020 онд мөлхөө, 2023 онд гипер, 2026 онд цогцо инфляци, 2020-2026 онд инфляци өссөн.
 E. 2020 онд гипер, 2023 онд цогцо, 2026 онд мөлхөө инфляци, 2020-2026 онд инфляци буурсан.

29. Нийлүүлэлт гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу. /1 оноо/

- A. Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ.
 B. Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ.
 C. Барааны зах зээлийн үнэ, үйлдвэрлэгчийн нийлүүлж байгаа барааны тоо хэмжээний хоорондын хамаарлыг хэлнэ.
 D. Тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, түүнийгээ арвижуулах үйл ажиллагааг хэлнэ.
 E. Эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж буй байдлыг хэлнэ.

30. 1989 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Монголын Ардчилсан холбооны анхны цуглаанд оролцогчдын дэвшүүлсэн уриа, лоозонд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Ардчилал бидний зорилт B. Хүнд суртлын аппаратыг устгая
 C. Социалист төрийн төлөө D. "Solidarity for Human rights"
 E. Олон намын тогтолцоо



31. Ардчиллын үнэт зүйлсийн тухай хүснэгтийг ажиглаад дутууг дараах хариултаас сонгоорой.

/1 оноо/

Ардчиллын үнэт зүйл	Иргэд төрийн хэрэгт оролцох нь тэдний эрх төдийгүй, иргэнийхээ хувьд хүлээж буй ёс суртахууны үүрэг юм.
	Ардчилсан нийгэм нь өөрсдийн удирдах засгаа тогтмол хугацаанд чөлөөт сонгуулиар байгуулдаг.
	

- A. Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог онцлогтой.
 B. Ардчилсан нийгэмд бүх хүн тэгш эрхтэй байх зарчим үйлчилнэ.
 C. Ардчилсан нийгэмд төрийн үйл ажиллагаа нээлттэй байснаар төрийг хянах боломж олгодог.
 D. Ардчилсан нийгэмд хүн бүр хуулийн хүрээнд ажиллаж, амьдрах үүрэгтэй.
 E. Ардчилсан нийгэмд цөөнхийн эрх олонхын хүсэл зоригоос үл хамаарна.

32. “Сонгодог ардчиллын онол”-ын аль хэсгийн ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Төр засаг ард түмнийхээ өмнө бүрэн хариуцлага хүлээх ёстой.	Төр, засаг нь ард түмнийхээ өмнө биш харин нам, бүлэг, лобби гэх мэт субъектүүдийн өмнө хариуцлага хүлээдэг.	Хүний эрх бол хэнээс ч үл хамаарах жам ёсны зүйл мөн.
2-р хэсэг	Хувь хүний хөгжих гол арга, улс төрийн амьдралд өргөн оролцох эрх боломжийг чухалчилдаг.	Олон түмэн өөрсдийн төр, засгаа сонгож байгуулдаг.	Дан ганц хувийн сонирхолд автдаггүй, ардчиллыг бататган хамгаалах үүрэг хүлээдэг.

- A. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн В
 B. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн А
 C. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн В
 D. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн Б
 E. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн А

33. 2012 оны УИХ-ын сонгуулиар 76 гишүүнтэй парламент бүрдүүлэхээр болжээ. Уг сонгуулиар парламентын 48 суудлыг мандатаар, 28 суудлыг намын жагсаалтаар бүрдүүлсэн бол сонгууль ямар тогтолцоогоор явагдсан бэ? /2 оноо/

- A. Мажоритар тогтолцоо, 48 нь мажоритар тогтолцоо, 28 нь пропорциональ тогтолцоо
 B. Холимог тогтолцоо, 28 нь мажоритар тогтолцоо, 48 нь пропорциональ тогтолцоо
 C. Мажоритар тогтолцоо, 48 нь холимог тогтолцоо, 28 нь пропорциональ тогтолцоо
 D. Мажоритар тогтолцоо, 28 нь холимог тогтолцоо, 48 нь мажоритар тогтолцоо
 E. Холимог тогтолцоо, 48 нь мажоритар тогтолцоо, 28 нь пропорциональ тогтолцоо

34. Алмонд, Верба нар өөрсдийн судалгаанд тулгуурлаж улс төрийн соёлын хэв маягуудыг боловсруулжээ. “Албатууд” (Subjects) гэсэн хэв маягт хамаарах ухагдахууныг сонгоно уу.

/2 оноо/

- A. Улс төр, төр засгийн талаар тун бүрхэг төсөөлөлтэй, голдуу бичиг үсэг мэдэхгүй, эсвэл улс төрийг огт тоож үздэггүй хүмүүс багтана.
 B. Төрийн түшмэд, хуульд идэвхгүй захирагдах боловч саналаа өгдөггүй, улс төрийн амьдралд идэвхтэй татагдан ордоггүй хүмүүс багтана.
 C. Улс төрийн үйл явцад бодитой оролцож байгаа эсвэл оролцоход бэлэн хүмүүс багтана.
 D. Улс төрийн амьдралын талаар мэдээлэлтэй байж, улс төрийн системд шаардлага тавьж түүнийхээ биелэлтээс хамааран эрх баригчдад дэмжлэг үзүүлэх эсэхээ шийдэж байдаг.
 E. Сонгуульд санал өгөх, нийгэм, улс төрийн амьдралд оролцох, албан тушаалтантай харилцана.



35. Арьсны өнгө, нас хүйс, үндэс угсаа, нийгмийн байдлаар нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь иргэний нийгмийг төлөвшүүлэх төрийн бодлогын аль хүрээнд хамаарах вэ? /1 оноо/

- A. Оюун санааны хүрээ B. Эдийн засгийн хүрээ C. Нийгмийн хүрээ
D. Улс төрийн хүрээ E. Эрх зүйн хүрээ

36. Улс төрийн засаглалын нийгмийн нөөцөд хамаарах өгөгдлийг сонгоно уу. /2 оноо/

- A. Хүн бол засаглалын нөөц төдийгүй бас засаглалын субъект, объект мөн.
B. Үйлдвэрлэл, хэрэглээнд шаардлагатай материаллаг үнэт зүйл, мөнгө санхүү, техник технологи, газар нутаг, ашигт малтмал зэрэг нөөц орно.
C. Арми, цагдаа, аюулгүйн алба, шүүх, прокурор зэрэг нь хүчний байгууллагын үндсэн цөм болно.
D. Улс төрийн бодлого хэрэгжүүлэх явцад засаглагч өөрийг нь дэмжинэ хэмээн тооцож найдаж байдаг нийгмийн бүлэг, давхраа юм.
E. Засаглалд ач холбогдол бүхий мэдлэг мэдээлэл, тэдгээрийг олж авах, түгээх арга хэрэгслүүдийн нийлбэр цогц юм.

37. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/

Сонирхлын бүлэг нь явцуу олон шаардлагыг цэгцлэн, нэгтгэн боловсруулах бөгөөд үүнийггэдэг.

- A. Интеграци B. Агрегаци C. Артикуляци D. Төр E. Эвсэл холбоо

38. Дараах улс орнуудын сонирхлын бүлэг, парламент хоорондын харилцааг зөв харгалзуулна уу. /2 оноо/

a. Герман улс	1	Сонирхлын бүлэг нь ихэвчлэн бизнесийн сонирхол дээр түшиглэдэг.
	2	Сонирхлын бүлгүүд нь яамдын сайдууд болон иргэний төлөөлөгч нартай харилцдаг.
b. ОХУ	3	Дэд хороо болон ажлын хэсэг нь сонирхлын бүлгээс мэргэжлийн хувьд заавар зөвлөгөө авч болохыг зөвшөөрдөг.
	4	Сонирхлын бүлгүүд засаг захиргаатай зөвшилцөлд хүрч чадахгүй байгаа нөхцөлд уг асуудлаа хуулиар шийдвэрлүүлдэг.

- A. a2, b3 B. a2, b4 C. a1, b2 D. a3, b4 E. a3, b1

39. Хүний эрхэм чанар гэсэн ойлголтод хамаарах өгөгдлийг олоорой. /1 оноо/

- A. Хүн бүр хүмүүн болохынхоо хувьд адил үнэ цэнтэй, тодорхой үндсэн эрх, эрх чөлөөг эдэлдэг.
B. Хүн бүр хаана, хэн болон төрж, хэрхэн амьдарч байгаагаас үл хамааран эрх тэгш байна.
C. Хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.
D. Төр заавал хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх, ахиц дэвшил гаргах ёстой.
E. Эрүүгийн хариуцлага нь хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох шинжгүй байх.

40. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

a. Сум, сум дундын шүүх	1	Иргэний хэргийн шүүх
b. Нийслэлийн шүүх	2	Анхан шатны шүүх
c. Улсын дээд шүүх	3	Давж заалдах шатны шүүх
	4	Хяналтын шатны шүүх

- A. a3b1c2 B. a2b3c4 C. a2b4c3 D. a4b1c2 E. a3b2c4

41. Иргэн Б оршин суугаа газрынхаа ойролцоо хүүхэд, залуучууд, хөгшдийн амралт, тав тухтай орчин бий болгох зорилгоор харьяа дүүргийнхээ албан тушаалтанд хандахаар шийдсэн. Энэ тохиолдолд иргэн Б захиргааны байгууллагатай ямар хэлбэрээр харилцах вэ? /1 оноо/

- A. Нэхэмжлэл гаргана B. Өргөдөл гаргана C. Гомдол гаргана
D. Захиргааны шүүхэд хандана E. Хүсэлт гаргана



42. Газрын тухай асуудлаар иргэд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч анхан шатны шүүхийн шийдвэрийг эс хүлээн зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд хандах хэрэгтэй болсон. Тэд давж заалдах шатны шүүхэд хэрхэн хандах вэ? /2 оноо/
- A. 30 хоногийн дотор дээд шатны захиргааны байгууллагаар дамжуулан нэхэмжлэл гаргана.
B. 14 хоногт орон нутагт, нийслэлд 7 хоногийн дотор шүүхээр дамжуулан нэхэмжлэл гаргана.
C. 30 хоногийн дотор шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гомдол гаргана.
D. 14 хоногийн дотор шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гомдол гаргана.
E. 14 хоногийн дотор дээд шатны захиргааны байгууллагаар дамжуулан гомдол гаргана.
43. А нь найз Б-ээс “Чи надад унадаг дугуйгаа 1 сарын хугацаатай хэрэглүүлээч, би хөлсөнд нь 50000 төгрөг өгье” гэж асуухад Б зөвшөөрчээ. Энэ тохиолдол дахь иргэний эрх зүйн харилцааны агуулгад үл хамаарах өгөгдлийг сонгоно уу. /2 оноо/
- A. Б нь мөнгийг А-аас шаардах
B. Б нь дугуйгаа хэрэглүүлэх санал тавих
C. Б нь дугуйгаа А-ийн ашиглалтад шилжүүлэх
D. А нь дугуйгаа шилжүүлж өгөхийг шаардах
E. А нь хөлс болох 50000 төгрөг төлөх
44. Хохирлоос шалтгаалан орлого, ашиг алдсан бол түүнийг гаргуулах нь гэм хорыг арилгах аль арга замд хамаарах вэ? /1 оноо/
- A. Эрүүл мэндэд B. Эд хөрөнгөд C. Сэтгэл санаанд D. Амь насанд E. Хор уршигт
45. Иргэд 16 наснаас хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцдог. Тэгвэл эцэг эхийн зөвшөөрлөөр хөдөлмөрийн гэрээ байгуулах нас хэд вэ? /1 оноо/
- A. 14 нас B. 15 нас C. 12 нас D. 18 нас E. 13 нас
46. Даатгуулагч А нь 55 настай, тэрээр тэтгэврийн нэмэгдэл олгох үндэслэлээр 12%-ийн нэмэгдэл авахаар болжээ. А нь нийт хэдэн жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бэ? /1 оноо/
- A. 28 B. 20 C. 8 D. 12 E. 26
47. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг ямар нөхцөлд олгох вэ? /2 оноо/
- A. Засгийн газрын тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй нөхцөлд олгоно.
B. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн нөхцөлд олгоно.
C. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн нөхцөлд олгоно.
D. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сараас доошгүй хугацаанд, сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
E. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
48. “Монгол улс бол сонгодог бага улс” хэмээх ойлголтод үл хамаарах өгөгдлийг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Орос, Хятад хоёр их гүрний дунд оршдог.	Эдийн засаг нь гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай.	Түүхий эд хэрэглээний бараа бүтээгдэхүүн нь хоёр хөршөөсөө хамааралгүй.
2-р хэсэг	Улс төрийн тогтвортой байдал бүрэн хангагдаагүй.	Хөрш улсууд, бүс нутагтай баттай нөлөөлж чаддаг. Эдийн засгийн тогтвортой хөгжилтэй.	Далайд гарцгүй, эх газрын байршилтай.

- A. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн В
C. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн Б
E. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн А

- B. 1-р хэсгийн В; 2-р хэсгийн Б
D. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн А



49. Монгол улс хоёр хөрштэйгөө харилцах зарчимд хамаарахгүй өгөгдөл аль нь вэ? /1 оноо/

- A. Олон тулгуурт B. Сайн хөршийн C. Хамтын ажиллагааны
D. Хүмүүнлэгийн E. Найрсаг

50. Монгол улс Орос улстай харилцах харилцааны тулгуур баримт бичгүүдийг зөв тохируулна уу. /2 оноо/

a. 1993 он	1	Москвагийн тунхаглалыг баталсан.
b. 2000 он	2	Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглалыг баталсан.
c. 2006 он	3	Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулсан.
	4	Улаанбаатарын тунхаглалыг баталсан.

- A. a3b2c1 B. a4b3c1 C. a3b4c1 D. a2b4c3 E. a4b3c2

51. Олон улсын төрийн бус байгууллагын үндсэн шинжид ул хамаарах өгөгдлийг сонгоно уу. /1 оноо/

1. Тодорхой чиглэл, хүрээнд зорилго тавьж хэрэгжүүлдэг.
2. Гишүүн улс орнуудын эрх ашгийг хамгаалдаг.
3. Улс орнуудын асуудалд анхаардаг.
4. Сайн дурын шинжтэй, иргэний нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

- A. 1, 4 B. 2, 3 C. 1, 3 D. 3, 4 E. 2, 4

52. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

a. Реалист онол	1	ОУХ-ны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг.
b. Неомарксист онол	2	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.
c. Неолиберал онол	3	ОУХ нь нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн юм.
	4	ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан корпорацууд, ЗГ-ын бус байгууллагууд, хувь хүмүүс байдаг.

- A. a1b3c4 B. a1b3c2 C. a3b2c1 D. a4b3c1 E. a3b2c4

53. Монгол улс ба АНУ-ын харилцааны тухай өгүүлэхдээ хамаарахгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Монголын 350 гаруй залуус дэлхийд алдартай Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан.
B. 1987 онд АНУ-ын Элчин сайдын яам Улаанбаатар хотод байгуулагдсан.
C. Таван толгойн цэргийн бэлтгэлийн баазад “Хааны эрэлд” цэргийн хамтарсан сургуулилалт хэрэгжүүлсэн.
D. 2001 оноос хоёр орон батлан хамгаалах салбарт хамтран ажиллах болсон.
E. “Энхтайван”-ы корпусын анхны сайн дурын ажилтнууд монгол хүүхэд, залуусыг англи хэл сурахад чухал дэмжлэг үзүүлсэн.

54. Монгол улс гуравдагч хөршийн бодлогын хүрээнд 2018 оны байдлаар Япон, Энэтхэг, БНСУ, АНУ, Герман, Турк, Канад, Австрали зэрэг улсуудтай түншлэлийн харилцаа тогтоосон. Эдгээр улсуудаас стратегийн түншлэл болон иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоосон улсуудыг сонгоно уу. /2 оноо/

- A. Стратегийн түншлэл- Япон, Турк; Иж бүрэн түншлэл- БНСУ, Энэтхэг, Австрали
B. Стратегийн түншлэл- Япон, Энэтхэг; Иж бүрэн түншлэл- АНУ, Герман, Турк
C. Стратегийн түншлэл- Энэтхэг, БНСУ; Иж бүрэн түншлэл- Япон, АНУ, Герман
D. Стратегийн түншлэл- Австрали, Япон; Иж бүрэн түншлэл- Энэтхэг, АНУ, Турк
E. Стратегийн түншлэл- БНСУ, Япон; Иж бүрэн түншлэл- АНУ, Герман



55. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/

..... гэдэг бол улсуудын харилцааг бэхжүүлэх, нийгэм, соёлын хамтын ажиллагааг бататгах буюу үндэсний эрх ашгаа хөхиүлэн дэмжих зорилгоор үзэл санаа, үнэт зүйл, уламжлал, соёлын бусад талуудын солилцоон дээр үндэслэдэг юм.

- A. Улс төрийн дипломат ажиллагаа B. Эдийн засгийн дипломат ажиллагаа
C. Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа D. Цахим дипломат ажиллагаа
E. Соёлын дипломат ажиллагаа

56. Бага улсууд гадаад бодлогодоо ямар стратегийг илүүд үзэж гадаад харилцаанд оролцох эрмэлзэлтэй байдаг вэ? /2 оноо/

- | |
|--|
| <ol style="list-style-type: none">1. ОУБ-ын үйл ажиллагааг дэмжин түүний ивээл дор гадаад харилцаанд оролцохыг эрмэлздэг.2. Хүч чадавх, нөөц бага тул хатуу хүчний бодлогыг чухалчилдаг.3. Эрх зүйн хүчинд чухал ач холбогдол өгч гадаад харилцаанд оролцдог.4. Их гүрний хүчинд дулдуйдаж хатуу хүчний бодлого явуулдаг.5. Улс орнуудын хүч чадавх нь эдийн засгийн хөгжил, цэрэг, зэвсэгт хүчин зэргээс хамаарна.6. Зөөлөн болон хатуу хүчийг хослуулан ухаалаг хүчний бодлогыг амжилттай хэрэгжүүлж байна. |
|--|

- A. 1, 3 B. 2, 5 C. 1, 4 D. 3, 6 E. 2, 3



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. Дараах онол болон сэтгэгчдийн үзэл санааг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a. Бүтэц чиг үүргийн онол	1	Нийгэм, эдийн засгийн индексийн аргачлал нь ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.
	2	Өмчөөс гадна эрх мэдлийн ялгарлыг чухалчилдаг. Төр нь ноёрхогч ангийн эрх ашгийг хэрэгжүүлж байдаг.
b. Зөрчилдөөний онол	3	Тухайн нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээрээ үнэлэгдэж, зэрэглэгдэж байдаг.
c. Дункан	4	Ангийн ялгааг авч үзэхдээ өмчөөс гадна орлого, эрхэлж буй ажил мэргэжил гэсэн эдийн засгийн бусад хүчин зүйлсийг чухалчилж үздэг.
d. Т.Парсонс	5	Ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаа, улмаар зөрчилд хүргэдэг гэсэн санаанд тулгуурладаг ч ангийн ялгарлыг өмчийн гэхээсээ эрх мэдлийн ялгаатай түлхүү холбон үздэг.
e. М.Вебер	6	Хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүргэх үндсэн шалтгаан гэж үздэг.
	7	Үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцааны ялгарлыг үйлдвэрлэлийн харилцаан дахь хянах эрх мэдлийн үзэл санаагаар баяжуулан судалсан.

2.2. Гадаад худалдаа, түүний тухай ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй зөв харгалзуулна уу. /5 оноо/

a. Портфелийн хөрөнгө оруулалт	1	Аж үйлдвэр нь өрсөлдөх чадвараар сул, хөгжиж байгаа улс орнууд болон гадаадын өрсөлдөөнийг дааж чадахааргүй, хөл дээрээ босож байгаа салбаруудад зайлшгүй хэрэгтэй юм.
	2	Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрийн газар байгуулах эсвэл худалдан авч болно.
b. Гадаад худалдааны хамгаалах бодлого	3	Үйлдвэрлэгчид шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнээ өсгөх зорилготой түр зуурын арга хэмжээ юм.
c. Импортын сөрөг тал	4	Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц юм.
d. Демпинг	5	Гадаадын компанийг хянах зорилгоор бус харин үнэт цааснаас ногдол ашиг болон үнэт цаасны ханшны өсөлтөөс орлого олох зорилготой.
e. Гадаад худалдааны бодлого	6	Импорт нэмэгдсэнээр дотоодын зах зээлд түүнтэй ижил төрлийн бараа үйлдвэрлэж байгаа эх орны үйлдвэрлэгчид хохирдог.
	7	Барааг экспортолсноор дотоодод тухайн барааны хомсдол үүсэж улмаар хэрэглэгчид хохирч болно.



2.3. Д.Истоны улс төрийн системийн загварын бүрдэл хэсгүүдийг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

a. Шаардлага	1	Төрийн бодлого шийдвэрт хэрхэн хандаж буйн илэрхийлэл, тогтворгүй байдлыг арилгах гол механизм
	2	Замын хөдөлгөөний дүрмийг сахих, төрийн дууллыг өглөө бүр хичээл эхлэхийн өмнө хүндэтгэлтэйгээр дуулах
b. Бодит дэмжлэг	3	Үе тэнгийн дээрэлхэлтийг зогсоох тухай өсвөр насныхны уриалга, жагсаал цуглаан
c. Шийдвэр	4	Хувийн эрх ашгийн төлөө бус иргэдийн эрх ашгийг илэрхийлэх зорилго бүхий сайн дурын нэгдэл
d. Эргэх холбоо	5	Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цагдаагийн байгууллага тусгай ажиллагааг зохион байгуулав.
e. Үйлдэл	6	Сургуулийн орчинд сурагч бусад сурагчийг дарамталж зүй бусаар харьцвал сургуулийн нийгмийн ажилтан багшийг 10 нэгж, сургуулийг 100 нэгжээр торгоно.
	7	2024 оны УИХ-ын сонгуулийн ирц өмнөх сонгуулиас эрс нэмэгджээ.

2.4. Хүний эрхийг хамгаалах Олон улсын болон Үндэсний механизмын тулгуур ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо	1	Аливаа эрх мэдэлд хязгаар бий. Хүн бүр эрхээ хамгаалуулахаар төр, засагт гомдол, шаардлага гаргах эрхтэй.
	2	МУ-ын Үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.
b. Хүний эрхийн үндэсний байгууллага	3	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ
c. Хүний эрхийг хамгаалах НҮБ-ын дүрэмд үндэслэгдсэн байгууллага	4	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан баримт бичиг
	5	Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, дэмжих, мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй ажилладаг.
d. Конвенц, пакт	6	Ерөнхий Ассамблей, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Аюулгүйн зөвлөл, Хүний эрхийн комисс гэх мэт
e. Хүний эрхийн үзэл баримтлалын шинж	7	НҮБ-ын олон улсын шүүх, Хүний эрхийн хороо Хүүхдийн эрхийн хороо, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо гэх мэт

